



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газар болон түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 1,627,905,392.96 (нэг тэрбум зургаан зуун хорин долоон сая есөн зуун таван мянга гурван зуун ерэн хоёр төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001921



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн  
 25/1 дүгээр тогтоолын хавсралт

**Иргэний нисэхийн ерөнхий газрын балансаас "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын Хөвсгөл аймгийн Автотээврийн төвд шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

Д/д	Автомашин <span></span> ы марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтанд орсон он	Тоо шир хэг	нийт гүйлт	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Тоёота Ланд круйзер маркийн, 22-55 УБЯ /49-18 УНЧ/улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар-ЈТМНН09Ј4С4055146	2012/2012	1	189900	132,347,350.00	71,688,147.93	60,659,202.07
			1		132,347,350.00	71,688,147.93	60,659,202.07
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1 (нэг)		132,347,350.00 (нэг зуун гучин хоёр сая гурван зуун дөчин долоон мянга гурван зуун тавин)	71,688,147.93 (далан нэгэн сая зургаан зуун наян найман мянга нэг зуун дөчин долоон төгрөг ерэн гурван мөнгө)	60,659,202.07 (жаран сая зургаан зуун тавин есөн мянга хоёр зуун хоёр төгрөг долоон мөнгө)